

“ШВЕД ДЭХ МОНГОЛЧУУДЫН ӨДӨРЛӨГ”-ИЙН ЭЭЛЖИТ АРГА ХЭМЖЭЭ БОЛНО

Written by Administrator

Monday, 14 October 2013 14:00 -

Монгол Улсын Элчин Сайдын Яам **Швед дэх Монголчуудын Үндэсний холбоо** **Монголын Залуучуудын Холбоо Швед дэх салбар зөвлөл**

ШВЕД ДЭХ МОНГОЛЧУУДЫН ӨДӨРЛӨГ - 6

2013 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр

Хөтөлбөр

09.30 Шатрын тэмцээнд оролцогчдын бүртгэл

10.00 “Швед дэх Монголчуудын 2013 оны шатрын аварга шалгаруулах тэмцээн”
- Эрэгтэй, эмэгтэй ангиллаар явагдана

13.00 “Элчин сайдын яамны мэдээлэл”
- Элчин сайд З.Алтай монгол иргэдтэй уулзаж, ЭСЯ-наас өнгөрсөн хугацаанд хийсэн ажлын талаар болон хийхээр төлөвлөж буй үйл ажиллагааны мэдээлэл хийнэ.

14.00 “Монголчууддаа өгөх бидний зөвлөгөө – Швед улсын татварын тогтолцоо, хөдөлмөр эрхлэж буй иргэдийн татвар төлөлт, түүний буцаалт” сэдвээр илтгэл тавьж, иргэдийн сонирхсон асуултад дэлгэрэнгүй мэдээлэл өгнө
/Т.Ариунаа, Норшопинг хотоос/

15.00 “Монголын Залуучуудын Холбооны Швед дэх Салбар зөвлөл”-ийн арга хэмжээ
Та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

хаяг: Соллентуна номын сангийн Аморина танхим / буудал - Sollentuna Pendeltåg station /-д болно

Монгол Улсаас Шведийн Вант Улсад суугаа ЭСЯ, Швед дэх Монголчуудын Үндэсний Холбоо, Монголын Залуучуудын Холбооны Швед дэх Салбар зөвлөл хамтран “Швед дэх Монголчуудын одорлог”-ийн ээлжит арга хэмжээг 2013 оны 11 дүгээр сарын 9-ний Бямба гарагт зохион байгуулна.

Энэ удаагийн одорлогийн вээр Стокгольм хотноо жил бүр уламжлал болон явагддаг шатрын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах бөгөөд Элчин сайд З.Алтай монгол иргэдтэй уулзалт хийн санал солилцож, ЭСЯ-наас онгорсон хугацаанд хийсэн ажлын талаар болон хийхээр төлөвлөж буй үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл огно.

Түүнчлэн Одорлогийн арга хэмжээний вээр Швед улсын татварын тогтолцооны талаар дэлгэрэнгүй танилцуулж, ходолморийн гэрээнд хамрагдан ажил эрхлэж байгаа монгол

“ШВЕД ДЭХ МОНГОЛЧУУДЫН ӨДӨРЛӨГ”-ИЙН ЭЭЛЖИТ АРГА ХЭМЖЭЭ БОЛНО

Written by Administrator

Monday, 14 October 2013 14:00 -

иргэдийн татвар тололт, түүний буцаалтыг хэрхэн авах талаар дэлгэрэнгүй мэдээлэл, зовлогоо огч, иргэдийн сонирхсон асуултад хариулт огно.

Мон энэ үеэр Монголын Залуучуудын Холбооны Швед дэх Салбар зовлоос “Номтой нохорлоо” салбар клубын талаар танилцуулж, олон улсын хэмжээнд болон Монголд хамгийн их борлуулалттай байгаа сүүлийн үеийн ном, зохиолын талаар мэдээлэл огч, уншсан номоо харилцан солилцох зэрэг арга хэмжээ болох тул Та бүхнийг оргоноор оролцохыг хүсье.

Энэ дашрамд “Швед дэх Монголчуудын одорлог”-ийн нийт арга хэмжээний үеэр хүүхдийн хуучин тоглоом болон видео тоглоомын солилцоо, худалдаа явагдах тул эцэг, эхчүүд хүүхдийнхээ хамт ирэх бололцоотой юм.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД